



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2025.02.24 № 246
танай _____ -ы № _____ -т

**ХЭНТИЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ДАШНАМЖИЛМАА ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг 3 төлбөрийн акт, 3 албан шаардлагын хамт хүргүүлж байна.

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг тогтоосон хугацаанд fas.audit.mn системд бүртгэн илгээж, аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Хавсралт 27 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Ж.ГАНБААТАР



232530245

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2025/189/НА-СТА-ТШЗ

Чингис хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Н.Туяа Утас: 99799709 Цахим хаяг: tuyan@audit.gov.mn Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2025.02.24

№

252

танай

-ны №

-т

ХЭНТИЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ДАШНАМЖИЛМАА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

Шагнал, ажлын хөлснөөс суутгасан 490.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг төсөвт төвлөрүүлээгүй, албан томилолтоор ажилласан хугацаатай давхардуулан 1,975.0 мянган төгрөгийн хоолны мөнгийг олгосон, тушаал шийдвэргүйгээр 1 ажилтанд 2,494.3 мянган төгрөгийн ээлжийн амралтын нөхөн олговрыг олгосон, 2,997.0 мянган төгрөгийн урамшууллыг төрийн албан хаагчийн улирлын ажлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон, 457,211.8 мянган төгрөгийн бараа материалын эд хариуцагчийн тайланг гаргаагүй, үндсэн хөрөнгийн данс дахь машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийн 441,289.0 мянган төгрөгийн үлдэгдэл, бараа материалын дансны тооллогыг хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй зөрчлүүд нь Хувь хүний орлогын албан татварын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

232520252

Тус байгууллага нь улсын төсвөөс 3,251,994.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 3,156,559.3 мянган төгрөг зарцуулж, 95,435.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 34,899.6 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 156,372.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 665.0 мянган төгрөг, нийт 191,937.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 191,937.3 мянган төгрөгийг зарцуулжээ.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 519,124.7 мянган төгрөгийн 11 алдаа зөрчил илэрснээс санхүүгийн тайланд 69,879.3 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 4,959.3 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 444,286.1 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өглөө.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 98 арга хэмжээ тусгагдаж, 90.8 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	562,458,003.14	457,471,800.07
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	00.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	00.00
33	АВЛАГА	14,425,966.00	00.00
335	Бусад авлага	14,425,966.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	14,425,966.00	00.00
34	УРЬДЧИЛГАА	27,551,850.00	00.00
34600	Урьдчилж гарсан зардал	27,551,850.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	520,480,187.14	457,471,800.07
351	Түүхий эд материал	415,438,727.80	281,900,935.73
35130	Эм боох материал	415,438,727.80	281,900,935.73
354	Хангамжийн материал	105,041,459.34	175,570,864.34
35410	Бичиг хэргийн материал	00.00	260,000.00
35420	Аж ахуйн материал	29,455,928.12	98,685,333.12
35430	Сэлбэг хэрэгсэл	11,222,510.10	11,222,510.10
35470	Бусад хангамжийн материал	64,363,021.12	65,403,021.12
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,011,371,779.33	891,423,382.83
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,011,371,779.33	891,423,382.83
392	Биет хөрөнгө	971,371,779.33	851,423,382.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	736,971,500.00	736,971,500.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-60,584,291.64	-75,357,150.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	336,388,536.99	302,888,536.99
39204	Хуримтлагдсан элэгдэл	-226,488,536.75	-214,688,536.97
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	322,973,524.64	327,505,524.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	-175,514,979.60	-256,437,339.27
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	99,722,029.43	99,722,029.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	-62,096,003.74	-69,101,181.99
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,061,505.20	14,061,505.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	-14,061,505.20	-14,141,505.20
393	Биет бус хөрөнгө	40,000,000.00	40,000,000.00
39301	Программ хангамж	462,000.00	462,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-462,000.00	-462,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	40,000,000.00	40,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,573,829,782.47	1,348,895,182.90
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	3,980,400.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	3,980,400.00
413	Өглөг	00.00	3,980,400.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	3,980,400.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,573,829,782.47	1,344,914,782.90
51	Засгийн газрын хувь оролцоо	1,573,829,782.47	1,344,914,782.90
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	876,621,728.80	876,621,728.80
51101	Өмч: - төрийн	876,621,728.80	876,621,728.80
512	Хуримтлагдсан үр дүн	681,967,289.75	453,052,290.18
51210	Өмнөх үеийн үр дүн	681,967,289.75	681,887,289.75
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-228,834,999.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,240,763.92	15,240,763.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,573,829,782.47	1,348,895,182.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,824,763,925.93	3,988,287,073.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	893,176,188.93	558,780,991.55
120	Нийтлэг татварын бус орлого	893,176,188.93	558,780,991.55
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	893,176,188.93	558,780,991.55
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	893,176,188.93	558,780,991.55
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,931,587,737.00	3,429,506,082.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,632,216,144.00	3,251,994,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,632,216,144.00	3,251,994,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	299,371,593.00	177,511,382.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	71,255,110.00	34,899,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	225,521,483.00	141,946,782.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,595,000.00	665,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,881,056,104.77	3,595,411,494.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,881,056,104.77	3,595,411,494.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,237,780,583.63	1,860,422,488.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	709,205,000.00	912,736,634.34
210101	Үндсэн цалин	417,542,317.25	535,362,637.93
210102	Нэмэгдэл	177,264,797.46	261,238,745.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	37,745,243.45	39,014,800.00
210104	Урамшуулал	76,652,641.84	77,120,450.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,700,591.04	115,367,236.88
210201	Тэтгэврийн даатгал	72,772,858.78	78,404,141.39
210202	Тэтгэмжийн даатгал	7,036,021.39	9,576,893.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,516,717.08	5,104,754.04
210204	Ажилгүйдлийн даатгал	1,299,250.26	4,597,372.11
210205	Эрүүл мэндийн даатгал	12,075,743.53	17,684,076.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,826,724.60	56,551,886.07
210301	Гэрэл, цахилгаан	5,687,954.60	6,428,670.07
210302	Түлш, халаалт	37,313,121.00	45,276,216.00
210303	Цэвэр, бохир ус	2,825,649.00	4,847,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,708,968.40	49,992,250.00
210401	Бичиг хэрэг	2,737,000.00	4,602,000.00
210402	Тээвэр, шатахуун	17,484,400.00	42,984,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,305,978.40	1,393,950.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	311,600.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	869,990.00	1,011,900.00
2105	Нормативт зардал	932,200.00	908,760.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	389,200.00	868,760.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	543,000.00	40,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,939,300.00	292,455,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,401,700.00	271,375,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,600,000.00	00.00
210604	Урсгал засвар	5,937,600.00	21,080,300.00

2107	Томилолт, зочны зардал	11,133,000.00	30,098,400.00
210702	Дотоод албан томилолт	11,133,000.00	30,098,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,103,974.20	9,824,335.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,709,900.00	1,859,995.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,800,000.00	2,700,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	576,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	253,116.00	208,040.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,285,958.20	4,413,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	326,230,825.39	392,487,586.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	231,078,909.20	267,577,190.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	404,000.00	510,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	94,747,916.19	124,400,396.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,643,275,521.14	1,734,989,005.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,438,267,087.20	1,639,553,565.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	877,387,942.20	580,508,561.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	560,879,145.00	1,051,268,004.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	7,777,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	205,008,433.94	95,435,440.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	205,008,433.94	95,435,440.71
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	943,707,821.16	392,875,579.05
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	574,527,199.58	621,710,578.62
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	574,527,199.58	621,710,578.62
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-574,527,199.58	-621,710,578.62
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	369,180,621.58	-228,834,999.57

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,931,587,737.00	3,443,932,048.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,931,587,737.00	3,443,932,048.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,632,216,144.00	3,251,994,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,632,216,144.00	3,251,994,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	299,371,593.00	191,937,348.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	71,255,110.00	34,899,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	225,521,483.00	156,372,748.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,595,000.00	665,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,931,587,737.00	3,443,932,048.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,931,587,737.00	3,443,932,048.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,283,767,156.86	1,708,943,042.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	722,060,573.13	908,756,234.34
210101	Үндсэн цалин	430,397,890.38	531,382,237.93
210102	Нэмэгдэл	177,264,797.46	261,238,745.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	37,745,243.45	39,014,800.00
210104	Урамшуулал	76,652,641.84	77,120,450.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,537,657.33	115,367,236.88
210201	Тэтгэврийн даатгал	72,772,858.78	78,404,141.39
210202	Тэтгэмжийн даатгал	7,036,021.39	9,576,893.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,516,717.08	5,104,754.04
210204	Ажилгүйдлийн даатгал	1,375,347.19	4,597,372.11
210205	Эрүүл мэндийн даатгал	12,836,712.89	17,684,076.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,826,724.60	56,551,886.07
210301	Гэрэл, цахилгаан	5,687,954.60	6,428,670.07
210302	Түлш, халаалт	37,313,121.00	45,276,216.00
210303	Цэвэр, бохир ус	2,825,649.00	4,847,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,708,968.40	49,992,250.00
210401	Бичиг хэрэг	2,737,000.00	4,602,000.00
210402	Тээвэр, шатахуун	17,484,400.00	42,984,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,305,978.40	1,393,950.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	311,600.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	869,990.00	1,011,900.00
2105	Нормативт зардал	932,200.00	1,568,760.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	389,200.00	868,760.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	543,000.00	700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,939,300.00	295,988,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,401,700.00	271,375,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,600,000.00	3,533,200.00
210604	Урсгал засвар	5,937,600.00	21,080,300.00
2107	Томилолт, зочны зардал	10,250,400.00	30,098,400.00
210702	Дотоод албан томилолт	10,250,400.00	30,098,400.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,103,974.20	9,824,335.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,709,900.00	1,859,995.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,800,000.00	2,700,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	576,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	253,116.00	208,040.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,285,958.20	4,413,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	359,407,359.20	240,795,340.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	359,003,359.20	240,285,340.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	404,000.00	510,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,647,820,580.14	1,734,989,005.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,437,367,087.20	1,639,553,565.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	877,387,942.20	580,508,561.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	559,979,145.00	1,051,268,004.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	7,777,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	210,453,492.94	95,435,440.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	210,453,492.94	95,435,440.71
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	836,738,409.10	4,341,541.00	-22,959,605.57	818,120,344.53
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	2,318,491.73	2,318,491.73
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	836,738,409.10	4,341,541.00	-20,641,113.84	820,438,836.26
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-2,318,491.73	00.00	-2,318,491.73
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	-116,680.30	00.00	-610,428.45	-727,108.75
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,621,728.80	15,240,763.92	681,967,289.75	1,573,829,782.47
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,621,728.80	15,240,763.92	681,967,289.75	1,573,829,782.47
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-80,000.00	-80,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	876,621,728.80	15,240,763.92	681,887,289.75	1,573,749,782.47
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-228,834,999.57	-228,834,999.57
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,621,728.80	15,240,763.92	453,052,290.18	1,344,914,782.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,364,148,600.00	3,156,559,259.3	207,589,340.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,364,148,600.00	3,156,559,259.3	207,589,340.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,364,148,600.0	3,156,559,259.3	207,589,340.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	933,796,600.00	908,756,234.3	25,040,365.66
210101	Үндсэн цалин	534,658,400.00	531,382,237.9	3,276,162.07
210102	Нэмэгдэл	265,903,400.00	261,238,745.9	4,664,654.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	55,552,100.00	39,014,800.0	16,537,300.00
210104	Урамшуулал	77,682,700.00	77,120,450.5	562,249.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,249,400.00	115,367,236.9	3,882,163.12
210201	Тэтгэврийн даатгал	79,169,800.00	78,404,141.4	765,658.61
210202	Тэтгэмжийн даатгал	10,019,900.00	9,576,893.1	443,006.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,009,900.00	5,104,754.0	-94,854.04
210204	Ажилгүйдлийн даатгал	5,009,900.00	4,597,372.1	412,527.89
210205	Эрүүл мэндийн даатгал	20,039,900.00	17,684,076.2	2,355,823.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,879,300.00	56,551,886.1	1,327,413.93
210301	Гэрэл, цахилгаан	11,156,200.00	6,428,670.1	4,727,529.93
210302	Түлш, халаалт	41,876,100.00	45,276,216.0	-3,400,116.00
210303	Цэвэр, бохир ус	4,847,000.00	4,847,000.0	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,216,000.00	49,992,250.0	223,750.00
210401	Бичиг хэрэг	4,602,000.00	4,602,000.0	0.00
210402	Тээвэр, шатахуун	42,984,400.00	42,984,400.0	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,410,000.00	1,393,950.0	16,050.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	205,800.00	-	205,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,013,800.00	1,011,900.0	1,900.00
2105	Нормативт зардал	1,629,200.00	1,568,760.0	60,440.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	916,600.00	868,760.0	47,840.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	712,600.00	700,000.0	12,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	336,233,100.00	295,988,600.0	40,244,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	311,875,100.00	271,375,100.0	40,500,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,533,200.00	3,533,200.0	0.00

210604	Урсгал засвар	20,824,800.00	21,080,300.0	-255,500.00
2107	Томилолт, зочны зардал	30,098,400.00	30,098,400.0	0.00
210702	Дотоод албан томилолт	30,098,400.00	30,098,400.0	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,499,700.00	9,824,335.0	675,365.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,998,400.00	1,859,995.0	138,405.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,059,700.00	2,700,000.0	359,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	576,900.00	576,900.0	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	259,700.00	208,040.0	51,660.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	67,300.00	66,000.0	1,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,537,700.00	4,413,400.0	124,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,880,500.00	52,357,992.0	522,508.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,925,900.00	51,847,992.0	77,908.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	954,600.00	510,000.0	444,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,771,666,400.00	1,636,053,565.0	135,612,835.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,771,666,400.00	1,636,053,565.0	135,612,835.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	713,538,400.00	580,508,561.0	133,029,839.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,053,849,900.00	1,051,268,004.0	2,581,896.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,278,100.00	4,277,000.0	1,100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,364,148,600.00	3,156,559,259.3	207,589,340.71
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,364,148,600.00	3,156,559,259.3	207,589,340.71
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,364,148,600.00	3,156,559,259.3	207,589,340.71
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	39	33	6
620001	Удирдах ажилтан	6	4	2
620002	Гүйцэтгэх ажилтан	26	23	3
620003	Үйлчлэх ажилтан	7	6	1

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	191,937,348.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	191,937,348.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	188,437,348.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	188,437,348.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	188,437,348.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	191,937,348.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	191,937,348.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,899,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	156,372,748.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	665,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг иргэн бүрд чанартай, аюулгүй хүртээмжтэй хүргэж, амьдралын чанарыг сайжруулснаар хүн амын дундаж наслалтыг уртасгахад оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1-т заасан дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1.эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

12.1.2.улсын хэмжээний үйлчилгээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттайгаас бусад эрүүл мэндийн байгууллага байгуулах, түүнд тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргаж, тухайн шатны Засаг даргад танилцуулах;

12.1.3.эмнэлгийн орыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хязгаарт багтаан зохицуулах;

12.1.4.харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих;

12.1.5.харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн статистик мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагын тайлан, мэдээ, мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллагад өгөх гэж заажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 224,854.6.0 мянган төгрөгөөр буюу 14.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	14,426.0	-	(14,426.0)
Урьдчилгаа	27,551.8	-	(27,551.8)
Бараа материал	520,480.2	457,471.8	(63,008.4)
Үндсэн хөрөнгө	1,011,291.8	891,423.4	(119,868.4)
Нийт хөрөнгө	1,573,749.8	1,348,895.2	(224,854.6)
Өр төлбөр		3,980.4	3,980.4
Засгийн газрын оруулсан капитал	876,621.7	876,621.7	-
Хуримтлагдсан үр дүн	681,887.3	453,052.3	(228,835.0)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,240.8	15,240.8	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,573,749.8	1,348,895.2	(224,854.6)

Дээрх хүснэгтээс харахад, авлагын дансанд нэмэлт данснаас улсын төсөвт төвлөрүүлсэн 14,426.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл барагдсан байна.

Урьдчилгаа дансанд сургалт зохион байгуулахаар урьдчилж гарсан 27,551.8 мянган төгрөгийн зардлыг тухайн сургалтыг зохион байгуулж зардалд хаасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 457,471.8 мянган төгрөг болж 63,008.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 248,150.4 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 554,249.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлого авч, 865,407.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны хувьд 4,532.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, 33,500.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд аудитаар 3,980.4 мянган төгрөгийн цалингаас суутгасан татварын өглөгийг тусгуулав.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,523,361.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 312,303.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,835,664.5 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалтын зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг улсын төсвөөс 3,364,148.6 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,251,994.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, 112,153.9 мянган төгрөгийн санхүүжилт дутуу ирсэн байна. Урсгал үйл ажиллагаанд 3,156,559.3 мянган төгрөг зарцуулж, 95,435.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, зардлын гүйцэтгэл 93.8 хувьтай байна.

Төсвийн зардлын гүйцэтгэл 3,156,559.3 мянган төгрөг буюу 93.8 хувьтай байгаа нь санхүүжилт дутуу ирсэн болон тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийг 133,029.8 мянган төгрөгөөр, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийг 2,581.9 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 40,244.5 мянган төгрөгөөр, цалин хөлсний зардлыг 25,040.4 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 3,882.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
					Зөрүү	Биелэлт
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,579,026.8	1,507,062.0	71,964.8	95.4
2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	1,771,666.4	1,636,053.6	135,612.8	92.3
3	83112	Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	13,455.4	13,443.7	11.7	99.9
		Дүн	3,364,148.6	3,156,559.3	207,589.3	93.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 34,899.6 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 156,372.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 665.0 мянган төгрөг, нийт 191,937.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 191,937.3 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Аудитын явцад авсан судалгааны талаар:

1. Тус байгууллага нь ахмадын байгуулаагүй байна.
2. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн судалгаагаар тус байгууллага нь 2024 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр сумдын Эрүүл мэндийн төвийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах 463,310.7 мянган төгрөгийн 17 багц тендерийг зарлаж, гүйцэтгэл 381,025.8 мянган төгрөг байна.
3. Төсвөөс 2024 онд зарцуулсан бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 1,860.0 мянган төгрөгийг ажил үйлчилгээний хөлс, төлбөр хураамжид төлжээ.
4. Төсвөөс 2024 онд зарцуулсан бараа үйлчилгээний бусад зардлаас 226,907.0 мянган төгрөгийг зарцуулснаас 38,469.6 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардлын бараа материал, ажил үйлчилгээний үнэд, 188,437.3 мянган төгрөгийг хөтөлбөр төслийн хүрээнд сургалт зохион байгуулах хоол цай, шатахуун, замын зардал, бичиг хэргийн материал, албан томилолт, арга хэмжээний шагналд зарцуулсан байна.
5. Байгууллагын 2024 оны орон тооны судалгаагаар 1,053,046.0 мянган төгрөгийн цалингийн сангийн зардал батлагдсанаас 1,024,123.5 мянган төгрөг зарцуулж 28,922.5 мянган төгрөгийг хэмнэсэн байна. Нийт 39 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 33 орон тоотой ажилласан байна. Үүнд: Удирдах 4, гүйцэтгэх 23, үйлчлэх 6 ажилтан байна. Үүнээс төрийн захиргааны 12, эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч 11, үйлчилгээний албан хаагч 10 байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторов дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Туяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 54 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,881,056.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 28,810.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 21,607.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Аудитын аудитын явцад материаллаг байдлыг дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хэмнэлтийн горимыг баримталж ажилласан байна. Аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах горим сорилыг хэрэгжүүлэхэд зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторов дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг шалгахад мэдээллийг 100 хувьтай мэдээлсэн байна. Үүнд таван сая төгрөгөөс дээш худалдан авалтын 70,129.5 мянган төгрөгийн 6, орлогын 3,416,631.3 мянган төгрөгийн 29 гүйлгээ, зарлагын 2,037,477.4 мянган төгрөгийн 180 гүйлгээ, хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой 18 тушаал шийдвэр, 762,051.5 мянган төгрөгийн 18 тендерийн мэдээлэл болон бусад мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тухайн байгууллага завсрын аудитад холбогдох баримт материалаа хамруулаагүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 10,454.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулж, шилэн дансанд 525,998.8 мянган төгрөгийн болон мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн мэдээлэх зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна. Зөрчлийг дахин давтахгүй байх 5 албан шаардлагыг хүргүүлснээс сахилгын шийтгэл ногдуулах 2, анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангаж ажиллах 1 албан шаардлагыг хэрэгжүүлж, эд хариуцагчийн тайлан гаргаагүй, үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй зөрчлийг арилгах 2 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, нийт шийдвэрийн хэрэгжилт 86.7 хувьтай байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	10,454.2	2	10,454.2	100.0
Албан шаардлага	5	561,053.7	3	4,900.0	60.0
Зөвлөмж	1	525,998.8	1	525,998.8	100.0
Нийт дүн	8	1,097,506.7	6	541,353.0	86.7

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар эд хариуцагчийн үндсэн хөрөнгө, бараа материалын тайлан болон хөрөнгийн тооллогыг хийж үлдэгдлийг баталгаажуулах албан шаардлагын хэрэгжилтийг авч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад санхүүгийн тайланд 69,879.3 мянган төгрөгийн 4 алдаа илэрснийг залруулсан. Үүнд:

1. Цалингийн зардлыг 6,586.1 мянган төгрөгөөр дутуу илэрхийлж, хувь хүний орлогын албан татварын 3,980.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй, өглөгөөр тусгаагүй.
2. Санхүүжилтийн орлогыг нэмэлт дансны авлага 14,426.0 мянган төгрөг, залруулгын 2 гүйлгээний 1,022.9 мянган төгрөг, нийт 15,448.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.
3. Авто тээврийн хэрэгслийн данснаас аймгийн ИТХ-ын тогтоолоор Зоонез өвчин судлалын төвд шилжүүлсэн 33,500.0 мянган төгрөгийн автомашиныг хасаагүй.
4. Тоног төхөөрөмжийн элэгдлийг тайлант онд 3,924.0 мянган төгрөгөөр, өмнөх онуудад 13,026.0 мянган төгрөгөөр, нийт 16,950.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлснийг тус тус залрууллаа.

Аудитаар нийт 449,245.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 4,959.3 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 444,286.1.0 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ. Үүнд:

5.1 Төлбөрийн акт

1. Шагнал, ажлын хөлснөөс суутгасан 490.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг төсөвт төвлөрүүлээгүй.
2. Ажилтнуудад албан томилолтоор ажилласан хугацаатай давхардуулан цалингийн зардлаас 1,975.0 мянган төгрөгийн хоолны мөнгийг олгосон.
3. Цалин хөлстэй давхардуулан тушаал шийдвэргүйгээр 1 ажилтанд 2,494.3 мянган төгрөгийн ээлжийн амралтын нөхөн олговрыг олгосон зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

1. ЭМГ-ын даргын тушаалаар 2023 оны ажлаар "Бүрэн хангалттай " дүн авсан ажилтнуудад тус бүр нэг сарын үндсэн цалингаар 2,997.0 мянган төгрөгийн урамшууллыг төрийн албан хаагчийн улирлын ажлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон.
2. Эд хариуцагч 457,211.8 мянган төгрөгийн бараа материалын эд хариуцагчийн тайланг гаргаагүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй.
3. Үндсэн хөрөнгийн данс дахь машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийн 441,289.0 мянган төгрөгийн үлдэгдэл, бараа материалын дансны тооллогыг хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй, тооцоог бодоогүй зөрчлүүдийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

1. Газартай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын нэр дээр эзэмшиж байгаа Баян-Овоо сум дахь сувиллын зориулалтын 10000 м2 газрыг орлогод бүртгэх ажлыг зохион байгуулаагүй. байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: ... 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага , 14.4.5.бүх орлого; ...;" гэсэн заалтад нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын эзэмшиж байгаа газрыг данс бүртгэлдээ орлогоор бүртгэх

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5¹ дугаар заалт, биелэлтийг 20.3² дахь заалтын дагуу 2025 оны 5 дугаар сарын 20-ны дотор тус тус ирүүлнэ үү.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг ирүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42.2³ дахь заалтын дагуу арга хэмжээ авахыг анхаарна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

² 20.3.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ.

³ 42.2.Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, энэ хуулийн 20.5-д заасан төлөвлөгөөг ирүүлээгүй нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулагда агүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингаас суутгасан татварыг өглөгөөр тусгаагүй	1	3,980.4	1	3,980.4			1	3,980.4				
Санхүүжилтийг илүү илэрхийлсэн	1	15,448.9			1	15,448.90	1	15,448.9				
Тээврийн хэрэгслийг данснаас хасаагүй	1	33,500.0	1	33,500.0			1	33,500.0				
Элэгдлийг дутуу тооцсон	1	16,950.0	1	16,950.0			1	16,950.0				
Дүн	4	69,879.3	3	54,430.4	1	15,448.90	4	69,879.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
шагналаас суутгасан татвар төсөвт төвлөрүүлээгүй	1	490.0	1	490.0								
Хоолны мөнгө давхардуулан олгосон	1	1,975.0	1	1,975.0								
Шийдвэргүйгээр мөнгө олгосон	1	2,494.3	1	2,494.3								
Эд хариуцагчийн тайлангүй	1	-			1	-						
Хөрөнгийн тооллого хийгээгүй	1	441,289.1			1	441,289.1						
Урамшуулал давхардуулан олгосон	1	2,997.0			1	2,997.0						
Газрыг орлогоор бүртгээгүй	1						1					
Дүн	7	449,245.4	3	4,959.3	3	444,286.1	1	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2025 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 109-ХЭА-2025/189/НА-СТА-ТШЗ
А2370447 Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд цалин хөлстэй давхардуулан тушаал шийдвэргүйгээр 1 ажилтанд 2,494.3 мянган төгрөгийн ээлжийн амралтын нөхөн олговрыг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Тушаал шийдвэргүйгээр олгосон ээлжийн амралтын нөхөн олговрын 2,494.3 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дашнамжилмаа, нягтлан бодогч Ц.Алтан-Өлзий нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Ж.ГАНБААТАР
Н.ТУЯА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 110-ХЭА-2025/189/НА-СТА-ТШЗ
А2370447 Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажилтнуудад албан томилолтоор ажилласан хугацаатай давхардуулан цалингийн зардлаас 1,975.0 мянган төгрөгийн хоолны мөнгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.2-т "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ.", 2.2.1-т "унааны зардал", 2.2.2-т "байрны зардал", 2.2.3. "хоолны зардал" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Давхардуулан олгосон 1,975.0 мянган төгрөгийн цалинг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дашнамжилмаа, нягтлан бодогч Ц.Алтан-Өлзий нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Н.ТУЯА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 111-ХЭА-2025/189/НА-СТА-ТШЗ
А2370447 Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шагнал, ажлын хөлснөөс суутгасан ХХОАТ-ын 490.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25.6. "Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.4-д "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төсөвт төвлөрүүлээгүй 490.0 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дашнамжилмаа, нягтлан бодогч Ц.Алтан-Өлзий нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Ж.ГАНБААТАР
Н.ТУЯА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 23

Дугаар 134-ХЭА-2025/189/НА-СТА-ТШЗ
А2370447 Чингис хот

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн сангаас Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар 2023 оны ажлаар "Бүрэн хангалттай" дүн авсан статистикч их эмч Д.Наранмичид, бага эмч Т.Ууганжаргал нарт тус бүр нэг сарын үндсэн цалингаар 2,997.0 мянган төгрөгийн урамшууллыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-т "Улирлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "Хуульд тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна.", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Урамшуулал давхардуулан олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дашнамжилмаа, нягтлан бодогч Ц.Алтан-Өлзий нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Н.ТУЯА | 232504134



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 23

Дугаар 135-ХЭА - 2025/189/НА - СТА-ТШЗ
А2370447

Чингис хот

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцэст санхүүгийн тайланд тусгагдсан үндсэн хөрөнгийн данс дахь машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийн 441,289.1 мянган төгрөгийн үлдэгдэл, бараа материалын дансны үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй, тооцоог бодоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 12.2. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1. жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2 "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана: 1/ үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-ээс 31-ний дотор/; 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс/;" гэсэн заалтуудад тус тус нийцээгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-д "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Хөрөнгийн тооллого хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дашнамжилмаа, нягтлан бодогч Ц.Алтан-Өлзий нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АУДИТОР

Н.ТУЯА

232504135



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 23

Дугаар 136-ХЭА-2025/189/НА-СТА-ТШЗ
А 2370447

Чингис хот

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эд хариуцагч бараа материалын тайланг тухай бүрд нь гаргаагүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2. "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", Сангийн сайдын 2000 оны 69 дүгээр тушаалаар батлагдсан Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 2.10 "Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид гаргаж өгнө" гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Эд хариуцагчийн тайланг тухай бүр гаргадаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дашнамжилмаа, нягтлан бодогч Ц.Алтан-Өлзий нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Н.ТУЯА

232504136